



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2023 онд УТХО-аар хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний 72.7 хувь нь бүрэн хэрэгжсэн бол 3 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байна.

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2024/18-17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Утас: 70363040	Б.Батмөнх
2024 он	Аудитын менежер	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Утас: 70363036	С.Баасансүрэн
	Ахлах аудитор	Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Утас: 70363036	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
	Аудитор Ж.Цогт	

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Ерөнхий мэдээлэл	4
А бүлэг: Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн, 8,555.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	5
A.1 Төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	5
A.2 2023 оны Төсвийн тухай хуульд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 2,779.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ нь тусгагдаагүй байна.	6
A.3 Тайлант онд 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгаа буюу 11.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.	8
Б бүлэг: Тайлант онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан 3 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.	10
B.1 Гэрээний хугацаанд нь батлагдсан зураг төсөв, техникийн шаардлагын дагуу 12 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	10
B.2 Төсөл, арга хэмжээний үе шат бүрд захиалагчийн болон зураг, төсөв зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсний үндсэн дээр улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан байна.	11
B.3 Захиалагч нь нийт 4,805.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгуулаагүй байна.	13
В бүлэг: Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан 12 төсөл, арга хэмжээний 91.7 хувийг зориулалтын дагуу ашиглаж байна.	14
V.1 Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан 11 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.	14
V.2 УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд цэцэрлэгийн хүүхдийн тоо болон эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн зэрэг эерэг үр дүн гарсан байна.	15
Илрүүлсэн зөрчил	17
Дүгнэлт	17
Зөвлөмж	18
Ирүүлсэн санал, тайлбар	19
Төрийн аудитын газрын тайлбар	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
БХБ	Барилга, хот байгуулалт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ	5
Хүснэгт 2	2023 оны Төсвийн хуульд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	7
Хүснэгт 3	Улсын комиссын актаар ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний жагсаалт	10
Хүснэгт 4	Улсын комиссын актаар ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний зориулалт, хүчин чадлын жагсаалт	14

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилго:	<p>Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.</p> <p>Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх, Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх,

	<ul style="list-style-type: none"> • <i>Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.</i>
<p>Аудитын хамрах хүрээ:</p>	<p>Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн аймгийн ТЕЗ, ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.</p> <p>Аудитад аймгийн ТЕЗ, ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглаж, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт:</p>	<p>Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглалаа.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, • Төсвийн тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Барилгын тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • Авто замын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, • УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, • Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, • Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга

	<p>хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”,</p> <ul style="list-style-type: none"> • Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт, • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт нар 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Ерөнхий мэдээлэл:</p>	<p>2023 оны Төсвийн тухай хуулиар УТХО-аар Сэлэнгэ аймагт өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 8 яаманд харьяалагдах нийт 38,283.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.</p> <p>2023 оны Төсвийн тухай хуульд өмнөх онд хэрэгжиж дуусаагүй нийт 2,779.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.</p> <p>2023 оны Төсвийн тухай хуульд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих нийт 19 төсөл, арга хэмжээнээс 2024 онд хэрэгжиж дуусахаар 4, тайлан онд хэрэгжиж дуусахаар 15 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан байна.</p> <p>Тайлант онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулагдсан нийт 4,472.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.</p>

**Бүлэг
А**

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн 8,555.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

А.1. Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу боловсруулсан уу?

Төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй 7 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

А.1.1 2023 оны Төсвийн тухай хуулиар УТХО-аар Сэлэнгэ аймагт өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 8 яаманд харьяалагдах нийт 38,283.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа-д харуулав./

А.1.2 Дээрх 19 төсөл, арга хэмжээнээс ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй, техникийн нөхцөл аваагүй, төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт өртөгт нь багтаан зураг, төсвийг хийлгэсэн зэрэг нийт 9,358.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ

Хүснэгт №1

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /2023 оны Төсвийн тухай хууль/	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан эсэх	Зураг төсөв боловсруулсан эсэх		Газрын зөвшөөрөл олгосон огноо	Техникийн нөхцөл олгосон огноо				Магадлалын ерөнхий дүгнэлт	
				Төсөв батлахын өмнө	Төсөв батлагдсаны дараа		Цахилгаан хангамж	Дулаан хангамж	Ус хангамж, ариутгах татуурга	Холбоо дохиолол	Огноо	Хянагдсан төсвийн дүн
1	Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	239.9	Батлаагүй		2022.02.10	Шаардлагагүй	-	-	2022.02.18	-	2022.08.30	249.7
2	Жишиг сум /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	3,980.0	2022.02.22		2022.11.09	Шаардлагагүй	2022.08.11	2022.08.12	2022.08.13	-	Түлхүүр гардуулах нөхцөлтэй	
3	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/	200.0	Батлаагүй		-	Шаардлагагүй	Шаардлагагүй				-	-
4	Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадны засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	1,715.1	Батлаагүй	2021.12.25	-	Шаардлагагүй	Шаардлагагүй				2022.04.18	1,800.0
5	Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/	783.8	Шаардлагагүй		2022.01.07-нд үнийн судалгаа хийсэн	Шаардлагагүй	Шаардлагагүй				Шаардлагагүй	
6	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	507.9	Батлаагүй	2018.08.27	-	Шаардлагагүй	2018.09.13	2018.09.12	-	-	2019.01.02	512.7
7	Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	1,932.0	Батлаагүй		2022.03.17	2022.03.09	-	-	-	-	-	-
Нийт дүн		9,358.7										

A.1.3 Дээрх хүснэгтээс үзэхэд:

- Нийт 4,594.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй байгаа нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.5¹ дахь заалтыг зөрчсөн,
- Нийт 3,980.0 сая төгрөг / төсөвт өртгийн давхцал нийт 2171,9 сая төгрөгийг хасаж тооцсон. / -ийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4², Барилгын тухай хуулийн 24.1.1³ дэх заалтыг тус тус зөрчсөн,
- 2 төсөл, арга хэмжээ /төсөвт өртгийн давхцалыг хасаж тооцсон./ зураг, төсвийг магадлал хийлгэж, баталгаажуулаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 25.2⁴, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.3⁵ дахь заалтыг тус тус зөрчсөн,
- Эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл / цахилгаан, дулаан, ус хангамж болон холбоо дохиоллын техникийн нөхцөл/ -ийг аваагүй 2 төсөл, арга хэмжээ /төсөвт өртгийн давхцалыг хасаж тооцсон./ -г баталсан байгаа нь Барилгын тухай хуулийн 37.1.3⁶, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.7⁷ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

A.1.4 Дээрхээс бусад төсөл, арга хэмжээнүүдийн зураг төсөв, ажлын даалгавар болон техникийн баримт бичгийг хууль тогтоомж, барилгын норм, дүрмийн дагуу боловсруулсан байна.

A.1.5 УТХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажуулаагүй нь төсөл арга хэмжээний явц, хэрэгжилт удаашрах, гэрээний хугацаанд хэрэгжих боломжгүй байдалд хүрэх, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх зэрэг эрсдэлүүдийг дагуулж байна.

A.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?

2023 оны Төсвийн тухай хуульд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 2,779.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ нь тусгагдаагүй байна.

¹ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

² Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³ Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 24.1.1. батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх.

⁴ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁵ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд заавал магадлал хийнэ.

⁶ Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.3.барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх.

⁷ Барилгын тухай хуулийн 22.2-т заасан инженер хангамжийн байгууллага захиалагчийн хүсэлтийг үндэслэн барилга байгууламжийн техникийн нөхцөлийг олгоно.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

A.2.1 Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 37.1.10: Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах” гэж заасан байдаг.

A.2.2 2021 онд зураг, төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулалгүй эхлүүлсэн дараах 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 2,470.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалж өнөөг хүртэл дуусаагүй, 2024 онд үргэлжлэн хэрэгжихээр батлагдсан байна. Үүнд:

- 1,100.0 сая төгрөгийн анхны төсөвт өртөг нь 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн магадлалын дүгнэлтээр 1,270.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 2,370.1 сая төгрөг болсон “Залуучуудын хөгжлийн ордны барилга /Сэлэнгэ, Сайхан сум/”,
- 1,000.0 сая төгрөгийн анхны төсөвт өртөг нь 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн магадлалын дүгнэлтээр 1,207.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 2,207.8 сая төгрөг болсон “Ахмадын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/”.

A.2.3 2023 оны Төсвийн тухай хуульд өмнөх онд хэрэгжиж дуусаагүй, ажлын гүйцэтгэл нь 46.6-83.6 хувьтай байгаа нийт 2,779.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 7 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

2023 оны Төсвийн хуульд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №2

/сая төгрөгөөр/

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл, арга хэмжээг эхлүүлсэн он	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр	Нийт олгосон санхүүжилт	Ажлын гүйцэтгэл хувиар
1	СоС	Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум/	Их засвар	2020	181.0	180.3	Оргилтаун констракшн ХХК	90.2	60%
2	ХЗДХС	Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	Барилга байгууламж	2022	200.0	200.0	Сэлэнгэ таван хан ХХК	-	-
3	БХБС	Цэвэрлэх байгууламжийн их засвар, шинэчлэл /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	Их засвар	2022	500.0	-	Гүйцэтгэгчээр шалгарсан компани гэрээ байгуулаагүй	-	-
4	БШУС	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг/	Их засвар	2020	180.0	179.3	Оргилтаун констракшн ХХК	88.0	50%
5	БШУС	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, Янзагахан цэцэрлэг/	Их засвар	2020	238.0	236.2	Эрдэнэт констрактив ХХК	188.7	80%
6	СоС	Мөнгөнхараа чуулгын байрны их засвар, тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Мандал сум/	Их засвар	2020	1,200.0	1,071.6	Марвелхаус констракшн ХХК	484.8	46.6%
7	ЭМС	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор /Сэлэнгэ, Жавхлант сум/	Барилга байгууламж	2021	280.0	279.9	Перфект смайл ХХК	234.2	83.6%
Нийт дүн					2,779.0	2,147.3		1,085.9	

A.2.4 Дээрх хүснэгтээс үзэхэд 2020, 2021 онд эхэлж, улсын төсвөөс нийт төсөвт өртгийн 46.6-83.6 хувьтай тэнцэх 88.0-484.8 сая төгрөгийн санхүүжилт авсан гүйцэтгэгч “Эрдэнэт констрактив”, “Оргил таун констракшн”, “Марвелхаус констракшн”, “Перфект смайл” ХХК-иуд нь гэрээний үүргээ биелүүлээгүйгээс 5 төсөл, арга хэмжээг өнөөг хүртэл ашиглалтад хүлээлгэж өгөөгүй байна. Үүнд:

- 181.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Спорт, сургалтын цогцолборын барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум/”,

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- 180.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг/”,
- 238.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, Янзагахан цэцэрлэг/”,
- 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мөнгөнхараа чуулгын байрны их засвар, тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Мандал сум/”,
- 280.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор /Сэлэнгэ, Жавхлант сум/”

А.2.5 Харин 2022 оны улсын төсөвт тусгагдаж, батлагдсан дараах 2 төсөл, арга хэмжээ огт хэрэгжиж эхлээгүй, төсвөөс санхүүжилт гараагүй байна. Үүнд:

- 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга” /Сэлэнгэ, Сүхбаатар сум/
- 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэвэрлэх байгууламжийн их засвар, шинэчлэл” / Сэлэнгэ, Сүхбаатар сум /

А.2.6 2023 оны Төсвийн тухай хуульд дээрхээс бусад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд бүрэн тусгагдсан байна.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?

Тайлант онд 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгаа буюу 11.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.

А.3.1 Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн явцын санхүүжилтийг хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн олгосон байна.

А.3.2 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэлийг үндэслэж, гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу явцын буюу 1, 2 дахь санхүүжилтийг 30.0-80.0 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

А.3.3 УТХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн Сайдын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/8591 дүгээр албан бичгээр аймгийн Засаг даргад чиглэл хүргүүлсэн байна.

А.3.4 Тайлант онд барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилт авахаар нэмэлт гэрээ байгуулсан “Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг 2023 оны санхүүжих дүн 105.8 сая төгрөгийн 3.0 хувь буюу 3.1 сая төгрөгөөр тооцож барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын чиглэл хүргүүлсэн дээрх албан бичгийн 2.1.5 дахь “Нэмэлт гэрээг байгуулахдаа гүйцэтгэлийн баталгааг тухайн төсөл, арга хэмжээнд батлагдсан төсөвт өртгөөс 2023 онд санхүүжих дүнгийн 3%-иар тооцож байршуулсан байх, ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

А.3.5 Улсын комиссын актаар хүлээж авсан 12 төсөл, арга хэмжээ /2021 онд 1, 2022 онд 3, 2023 онд 8 төсөл, арга хэмжээ/ -ний эцсийн санхүүжилтийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.29⁸, 4.1.30⁹-д заасны дагуу барилга байгууламж, их засварын ажлын хяналтын хуудас, гүйцэтгэлийн төсвийг үндэслэн “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулж олгосон байна.

А.3.6 Дээрх 12 төсөл, арга хэмжээний чанарын баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулахаар гэрээнд тусгасан бөгөөд өмнөх онд 2 төсөл, арга хэмжээний барьцааг байршуулсан байна.

А.3.7 Тайлант онд гэрээний дагуу 9 төсөл, арга хэмжээний чанарын баталгаа буюу 1,089.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

А.3.8 Харин “Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээний чанарын баталгаа буюу 11.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.2 дахь “Захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:2.3.2.5.барилга байгууламжийн ... чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэсэн заалт болон ажил гүйцэтгэх гэрээний “Тусгай нөхцөл”-ийн 48 дахь “... ажлыг бүрэн хүлээлгэж өгсний дараа үлдээдэл санхүүжилт 35 хувийг олгоно. ... гомдол санал гараагүй бол барьцаа гэрээний дүнгийн 5 хувийг олгоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

А.3.9 2020, 2021 онд эхэлж, өнөөг хүртэл ашиглалтад хүлээлгэж өгөөгүй, санхүүжилтийг нь хөрөнгө оруулалтын барьцааны дансанд байршуулсан дараах 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт 391.9 сая төгрөгийг Сангийн яамны зөвшөөрлийн дагуу гүйцэтгэгчид олгосон байна. Үүнд:

- 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мөнгөн хараа чуулгын байрны их засвар /Сэлэнгэ, Мандал сум/” төсөл, арга хэмжээний 346.2 сая төгрөгийг гүйцэтгэгч Марвелхаус констракшн ХХК-д,
- 279.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор /Сэлэнгэ, Жавхлант сум/” төсөл, арга хэмжээний 45.7 сая төгрөгийг гүйцэтгэгч Перфект смайл ХХК-д тус тус олгосон.

**Бүлэг
Б**

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан эсэх

Тайлант онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан 3 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.

⁸ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу бөглөн баталгаажуулж ирүүлнэ.

⁹ Төслийн эцсийн санхүүжилтийг ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

Б.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?

Гэрээний хугацаанд нь батлагдсан зураг төсөв, техникийн шаардлагын дагуу 12 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Б.1.1 2023 оны Төсвийн тухай хуульд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 19 төсөл, арга хэмжээнд /Барилга байгууламжийн 16, их засварын 2, тоног төхөөрөмжийн 1/ -нд /Дэлгэрэнгүйг Судалгаа-д харуулав / дараах гэрээг байгуулсан байна. Үүнд:

- Барилгын материалын үнийн зөрүүгээр нэмэлт гэрээ байгуулсан 4 / улсын комиссын актаар 2021 онд 1, 2022 онд 3 төсөл, арга хэмжээг хүлээж авсан/.
- 2024 онд хэрэгжиж дуусахаар 4 төсөл, арга хэмжээ.
- 2023 онд хэрэгжиж дуусахаар 11 төсөл, арга хэмжээ.

Б.1.2 Тайлант онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний 72.7 хувь буюу нийт 13,645.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ /барилга байгууламжийн 6, их засварын 1, тоног төхөөрөмж 1/ нь барилгын норм дүрэм, батлагдсан зураг, төсвийн болон техникийн шаардлагын дагуу гэрээний хугацаанд бүрэн хэрэгжээнийг улсын комиссын актаар хүлээн авч, ашиглалтад оруулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Улсын комиссын актаар ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн	Төсөвт өртөг /2023 оны Төсвийн тухай хуулиарх/	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн нэр	Улсын комиссын актаар хүлээж авсан огноо
1	III.1.5	Засаг даргын Тамгын газрын барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	2020	795.8	Грийнвишн ХХК	2023.11.09
2	IV.1.11	Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2022	239.9	Сэлэнгэ Ундрэм ХХК	2023.10.09
3	VIII.1.1.8	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2021	3,090.8	Бүрэн-Одод ХХК	2023.12.18
4	IX.1.85.6	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/	2022	200.0	Алтынсапа ХХК	2023.07.06
5	IX.2.18	Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадын засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	2022	1,715.1	Чингисийн төгөл ХХК	2023.10.15
6	X.1.1.119	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Ерөө сум/	2020	2,982.9	Таванхан уул ХХК	2022.12.14
7	X.1.1.196	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Түшиг сум/	2021	659.6	Баян Өндөр булаг ХХК	2022.11.23

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

8	X.1.2.8	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр сургууль/	2021	371.9	Танан цамхаг ХХК	2021.10.25
9	X.1.3.14	Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/	2022	783.8	Синапс ХХК	2023.05.09
10	XII.2.1.2	Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/	2020	6,312.5	Эрдэнэт суврага ХХК	2023.08.28
11	XII.2.1.6	Хяраан голын гүүр /Сэлэнгэ, Алтанбулаг сум, 3 дугаар баг/	2020	618.3	Хайвай интернейшнл ХХК	2022.11.22
12	XV.1.51	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	2022	507.9	Девсофт ХХК	2023.12.13
Нийт дүн				18,278.5		

Б.1.3 Харин тайлант онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан нийт 4,472.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 3 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.Үүнд:

- 550.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/,
- 1,989.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Сэлэнгэ, Баянгол сум/,
- 1,932.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн лабораторийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/.

Б.1.4 Бүрэн хэрэгжээгүй нийт 3,921.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг 2024 он хүртэл сунгасан бол 550.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгаагүй байна.

Б.1.5 Тайлант онд бүрэн хэрэгжээгүй дээрх 1 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгаагүй байгаа нь гүйцэтгэл удаашрах, улмаар хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Б.1.6 1,989.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Сэлэнгэ, Баянгол сум/” төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл 97.8 хувьтай хэрэгжсэн бөгөөд ашиглагч Баянгол сумын ЗДТГ нь дулааны улирал эхлэхээр хүлээж авах санал гаргасан байна.

Б.1.7 Техникийн нөхцөлийг бүрэн аваагүй, зураг, төсвийг урьдчилан хийлгээгүй, магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй 2 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлснээс шалтгаалж гэрээт хугацаанд бүрэн хэрэгжээгүй байна.

Б.2. Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж, заавар журмын дагуу бүх шатны хяналтыг хэрэгжүүлж, хүлээн авсан уу?

Төсөл, арга хэмжээний үе шат бүрд захиалагчийн болон зураг, төсөв зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсний үндсэн дээр улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан байна.

Б.2.1 2023 оны Төсвийн тухай хуулиар баталсан өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 18 /*тоног төхөөрөмж нийлүүлэх 1 төсөл арга хэмжээ хасагдсан*/ төсөл, арга хэмжээний барилга байгууламж, их засварын ажилд Барилгын тухай хуулийн 37.1.4¹⁰, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “*Барилгын ажлын захиалагчийн дүрэм*”-ийн 3.12¹¹-т заасны дагуу байгуулсан гэрээний үндсэн дээр аймгийн ГХБХБГ-аас захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

Б.2.2 Тус газрын Барилгын хэлтсийн дарга, инженерүүд нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “*Барилгын ажлын захиалагчийн дүрэм*”-ийн 3.9¹², 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам*”-ын 5.2¹³ болон 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам*”-ын 5.3¹⁴ заасны дагуу үе шат бүрд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, хяналтын тайлангаар баталгаажуулсан байна.

Б.2.3 Барилгын тухай хуулийн 37.1.5¹⁵, “*Барилгын ажлын захиалагчийн дүрэм*”-3.1.4¹⁶-т заасны дагуу дээрх 18 төсөл, арга хэмжээнд зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч аж ахуйн нэгж, байгууллагуудаар гүйцэтгүүлсэн байна.

Б.2.4 Зураг, төсөв зохиогчийн хяналтыг БХБ-ын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “*Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм*”-ийн 3.2.3¹⁷, Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам*”-ын 5.2.3¹⁸-т заасны дагуу төсөл, арга хэмжээний үе шат бүрд хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулан, “*Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт*”-ээр баталгаажуулсан байна.

Б.2.5 Явцын хяналтыг гэрээний дагуу хэрэгжүүлсэн боловч гэрээт хугацаанд ашиглалтад оруулаагүй 3 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг 70.4-97.8

¹⁰ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

¹¹ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

¹² Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

¹³ Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

¹⁴ Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

¹⁵ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

¹⁶ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

¹⁷ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан гүйцэтгэнэ: 3.2.3 барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

¹⁸ Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

хувиар хянаж, баталгаажуулан нийт 2,477.4 сая төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгосон байна.

Б.2.6 Харин он дамжин хэрэгжиж 2024 онд ашиглалтад орох 4 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг 48.3-87.4 хувиар хянаж, баталгаажуулан тайлант онд 4,806.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Б.2.7 Барилга байгууламж, их засвараас бусад буюу 783.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “*Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/*” төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсэг */Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ОНӨГ, Боловсрол, шинжлэх ухааны газрын холбогдох мэргэжилтнүүд оролцсон/* захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Б.2.8 Захиалагч нь төсөл, арга хэмжээний явцын санхүүжилтийг гэрээнд заасны дагуу гүйцэтгэгчийн хүсэлт, эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан барилгын ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон бол улсын комиссын актаар ашиглалтад оруулсан 12 төсөл, арга хэмжээ */Тоног төхөөрөмж 1, барилга байгууламж, их засварын 11/* -ний эцсийн санхүүжилтийг “*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам*”-ын 4.1.29¹⁹, 4.1.30²⁰-д заасны дагуу хяналтын хуудас болон “*Гэрээ дүгнэх маягт*”-аар баталгаажуулсны үндсэн дээр олгосон байна.

Б.2.9 Ашиглалтад хүлээн авсан 12 төсөл, арга хэмжээнд нийт 18,076.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем */pimis.publicinvestment.gov.mn/*-ээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн, захиалагчийн хяналтын нэгдсэн дүгнэлт, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

Б.3.Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу ?

Захиалагч нь нийт 4,805.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгуулаагүй байна.

Б.3.1 Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан 12 төсөл, арга хэмжээ */2021 онд 1, 2022 онд 3, 2023 онд 8/* -ний 9-г нь ашиглагч байгууллагууд болох аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Алтанбулаг, Баруунбүрэн сумдын ЗДТГ, Мандал сумын 1 дүгээр сургууль, Ерөө, Түшиг сумдын цэцэрлэг, Цагааннуур сумын Эрүүл мэндийн төв, “Сэлэнгэ цэнгэг ус” “Тохилог хараа” ААТҮГ зэрэг ашиглагч байгууллагуудын хөрөнгийн бүртгэлд тусгасан байна.

Б.3.2 Харин нийт 4,805.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна. Үүнд:

¹⁹ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу бөглөн баталгаажуулж ирүүлнэ.

²⁰ Төслийн эцсийн санхүүжилтийг ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- 3,090.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”,
- 1,715.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадын засвар /Сэлэнгэ, Сайхан сум/”.

Б.3.3 Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ...”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.31 дэх “Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж, баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Б.3.4 Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсгийн 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 01/2023 дугаар актаар 6,312.5 сая төгрөг /Төсвийн тухай хуулиар 2021 онд 1,000.0 сая төгрөг, 2022 онд 4,500.0 сая төгрөг, 2023 онд 812.5 сая төгрөг/ -ийн төсөвт өртөгтэй “Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/” төсөл, арга хэмжээг хэсэгчлэн ашиглалтад оруулсан тул тайлант онд хөрөнгөд бүртгээгүй байна.

Бүлэг В

Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан 12 төсөл, арга хэмжээний 91.7 хувийг зориулалтын дагуу ашиглаж байна.

В.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?

Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан 11 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

В.1.1 Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан 12 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

Улсын комиссын актаар ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний зориулалт, хүчин чадлын байдал

Хүснэгт №4

№	Төсөл, арга хэмжээний нэр	Ашиглалтад хүлээн авсан огноо	Ашиглалтын байдал		Тайлбар
			Зориулалтын дагуу	Хүчин чадал	
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	2023.11.09	Тийм	Тийм	Сумын ЗДТГ-т нийт 28 албан хаагч ажиллаж байна.
2	Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2023.10.09	Тийм	Тийм	“Сэлэнгэ Цэнгэг ус” ААТҮГ-ын өмчлөлд шилжүүлсэн.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

3	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2023.12.18	-	-	Дулааны шугамд холбогдоогүйгээс үйл ажиллагаа эхлээгүй.
4	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/	2023.07.06	Тийм	Тийм	“Тохилог хараа” ААТҮГ-ын өмчлөлд шилжүүлсэн, ашиглаж байгаа.
5	Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадын засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	2023.10.15	Тийм	Тийм	13 байрны гадна фасадыг бүрэн засварласан.
6	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Ерөө сум/	2022.12.14	Тийм	Тийм	33 багш, ажилтан, 295 хүүхэд суралцаж байна.
7	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Түшиг сум/	2022.11.23	Тийм	Тийм	5 багш, ажилтан, 62 хүүхэд суралцаж байна.
8	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр сургууль/	2021.10.25	Тийм	Тийм	Сургуулийн 60 ширхэг цонхыг сольж, шалыг засварласан.
9	Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/	2023.05.09	Тийм	Тийм	204 нэр төрлийн 15,274 ширхэг тоног төхөөрөмжийг аймгийн 34 сургуульд хүлээлгэн өгсөн.
10	Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/	2023.08.28	Тийм	Тийм	193.5 метрийн урттай гүүр барьсан.
11	Хяраан голын гүүр /Сэлэнгэ, Алтанбулаг сум, 3 дугаар баг/	2022.11.22	Тийм	Тийм	12.7 метрийн урттай гүүр барьж, ашиглалтад оруулсан.
12	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	2023.12.13	Тийм	Тийм	15 ортой хэвтэн эмчлүүлэх тасаг ажиллаж байна.

В.1.2 Дээрх хүснэгтээс үзэхэд 2021 онд 1, 2022 онд 3 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан боловч барилгын материалын үнийн зөрүүг 2023 оны Төсвийн тухай хуульд тусгаж, нэмэлт санхүүжилтийг олгосон байна.



Цэцэрлэгийн барилга, 200 ор
/Сэлэнгэ, Ерөө сум/



Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор
/Сэлэнгэ, Цагааннуур сум/

В.1.3 Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ төсөл, арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн улсын комиссын актаар дулааны улиралд гадна дулааны шугамын холболт, тохижилтын ажлыг хийж дуусгах үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авсан байна.

В.2 Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд цэцэрлэгийн хүүхдийн тоо болон эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн зэрэг эерэг үр дүн гарсан байна.

В.2.1 Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан төсөл, арга хэмжээний 4 нь боловсролын, 2 нь зам гүүрний, 2 нь нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ногоон байгууламжийн, бусад нь хүүхэд хамгаалал, эрүүл мэнд, нийтийн эзэмшлийн байрны фасадын засвар, сумын ЗДТГ-ын барилга байна.

В.2.2 Бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан дээрх 12 төсөл, арга хэмжээний 11 нь аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилтууд болон орон нутгийн тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна. Тухайлбал:

- 239.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум”, 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/ төсөл, арга хэмжээнүүд нь агаар, ус хөрсний бохирдлыг багасгаж, иргэдийн амьдрах ээлтэй орчин бүрдүүлэх ач холбогдолтой болсон.
- 2,982.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилга, 200 ор / Сэлэнгэ, Ерөө сум”, 659.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Түшиг сум/” төсөл, арга хэмжээнүүд хэрэгжсэнээр СӨБ-ын стандартын шаардлага хангасан, ая тухтай орчинд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаанд сайнаар нөлөөж, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо нэмэгдсэн,
- 783.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөнхий боловсролын сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/” төсөл, арга хэмжээ нь аймгийн хэмжээний 34 сургуулийг физик, хими, технологийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангагдсанаар 3 хичээлийн сургалтын чанарт сайнаар нөлөөлж, сурагчдын сурлагын амжилтыг ахиулах боломж бүрдсэн,
- 371.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр сургууль/” төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр тухайн сургуулийн багш, сурагч болон бусад ажиллагсад эрүүл, ая тухтай орчинд ажиллаж, сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл боломжийг нэмэгдүүлсэн,
- 507.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор /Сэлэнгэ, Цагааннуур/” төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр тус сумын ЭМТ нь эмчилгээний болон эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан орчинд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлснээр хэвтэн эмчлүүлэгчийн тоо нэмэгдсэн,
- 6,312.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/, 618.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хяраан голын гүүр /Сэлэнгэ, Алтанбулаг сум, 3 дугаар баг/ төсөл, арга хэмжээнүүд хэрэгжсэнээр тухайн сумын иргэдийн аюулгүй зорчих, ээлтэй орчныг бүрдүүлсэн байна.

В.2.3 Харин хэдийгээр тодорхой хэмжээний иргэдийн эрх ашигт нийцсэн боловч Төсвийн тухай хуулийн 4.1.24²¹ дэх заалтыг зөрчсөн, төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй 1,715.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “*Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасадын засвар*” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **4,820.9** сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилт авахаар нэмэлт гэрээ байгуулсан “*Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/*” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг 2023 оны санхүүжих дүнгээс тооцож, барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй 3,1 сая төгрөг.
- “*Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/*” төсөл, арга хэмжээний чанарын баталгааг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй 11.9 сая төгрөг.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй 4,805.9 сая төгрөг.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй 7 төсөл, арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна.
- 2023 оны Төсвийн тухай хуульд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 2,779.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.
- Тайлант онд 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгаа буюу 11.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.
- Барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилт авахаар нэмэлт гэрээ байгуулсан 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа болох 3.1 сая төгрөгийг байршуулаагүй байна.
- Гэрээний хугацаанд нь батлагдсан зураг төсөв, техникийн шаардлагын дагуу 12 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.
- Төсөл, арга хэмжээний үе шат бүрд захиалагчийн болон зураг, төсөв зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсний үндсэн дээр улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан байна.
- Нийт 4,805.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

²¹ 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:4.1.24. “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Улсын комиссын актаар ашиглалтад хүлээж авсан 11 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.
- УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд цэцэрлэгийн хүүхдийн тоо болон эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн, иргэдийн амьдрах таатай орчин бүрдсэн зэрэг эерэг үр дүн гарсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлж, хэрэгжүүлж байх.
- Барилгын материалын үнийн өсөлтийн зөрүүг авахаар нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг Сангийн сайдын хүргүүлсэн чиглэлийн дагуу холбогдох дансанд байршуулж байх.
- 2020, 2021 онд эхэлсэн боловч хэрэгжиж дуусаагүй болон орхигдсон төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад оруулах замаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх.
- Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд гэрээний дагуу хариуцлага тооцож, гэрээт ажлыг дуусгуулах арга хэмжээ авах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
С.БААСАНСҮРЭН
Ж.ЦОГТ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn

2024.04.17 № 01/482

танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

“Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна.

Хавсралт ___ хуудастай




Н.ЛХАГВАДОРЖ

Cuser/albanbichig2024/jijig tootAS

430800554

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024
оны 04 дүгээр сарын 17 -ны өдрийн
01/432 дугаар албан бичгийн хавсралт



Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын
2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн
аудитын тайлангийн төсөлд санал хүргүүлэх

№	Аудитаар илэрсэн зөрчлийн товч утга	Санал
1	Барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилт авахаар нэмэлт гэрээ байгуулсан “Халуун усны барилга /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг 2023 оны санхүүжих дүн 105.8 сая төгрөгийн 3 хувь буюу 3.1 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна.	Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч байна.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.
2	239.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум” төсөл, арга хэмжээний чанарын баталгааг гэрээний дүнгийн 5 хувиар тооцож, 11.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.	Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч байна.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.
3	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд хэрэгжсэн 4,805.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.	Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч байна.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 21.4 хувь нь дутуу болон огт хэрэгжээгүй бөгөөд хэрэгжилт, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2024/18-17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Утас: 70363040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер Утас: 70363036	Б.Батмөнх Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
2024 он	Ахлах аудитор Утас: 70363036	С.Баасансүрэн Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Аудитор Ж.Цогт	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Ерөнхий мэдээлэл	4
А бүлэг: Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, иргэдийн санал аваагүй, хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцээгүй төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна	5
А.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтыг бүрэн хангаагүй, иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна	5
А.2. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна	7
А.3. Төсвийн тодотголоор батлагдсан, хэрэгжүүлэх хугацаа оройтсон 870.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна	11
Б бүлэг: 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 21.4 хувь нь дутуу болон огт хэрэгжээгүй байна	13
Б.1. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 136 төсөл, арга хэмжээ буюу 78.6 хувь нь бүрэн хэрэгжсэн байна	13
Б.2. 3 сум нь 269.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна	15
Б.3. Тайлант онд бүрэн хэрэгжсэн 33 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд нь бүртгэл тайланд тусгаагүй байна	17
Б.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаагүй байна	19
Илрүүлсэн зөрчил	21
Дүгнэлт	21
Зөвлөмж	22
Ирүүлсэн санал, тайлбар	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сумдын 2023 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	5
Хүснэгт 2	Улсын төсвийн байгууллагуудын урсгал зардлыг санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ	9
Хүснэгт 3	Өмнөх оноос шилжиж ирсэн дутуу болон огт хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ	14
Хүснэгт 4	Магадалшгүй ажлын зардлыг бүрдэл дутуу анхан шатны баримтаар олгосон төсөл, арга хэмжээ	18

Дүрслэлийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Батлагдсан төсөл, арга хэмжээ / төсөл, арга хэмжээний тоонд эзлэх хувиар/	8
Дүрслэл 2	Батлагдсан төсөл, арга хэмжээ /төсөвт өртгөөр,	8
Дүрслэл 3	Салбаруудад хуваарилсан төсөл, арга хэмжээ /төсөвт өртгөөр/	19

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
--	--

<p>Аудитын зорилт:</p>	<p>Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, төлөвлөсөн үү?</i> ➤ <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгүүлж, хүлээн авсан уу?</i>
<p>Аудитын хамарсан хүрээ:</p>	<p>Аудитад орон нутгийн төсвийн 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, худалдан авах ажиллагааны баримт материалууд, аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, аймгийн Худалдан авах ажиллагааны газар, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудыг хамруулав.</p>
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.</p> <p>Аудитад аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны газар, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглаж, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт:</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэх, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хууль, • Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Барилгын тухай хууль, • Авто замын тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

	<ul style="list-style-type: none"> • Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, • Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2022 оны 83 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”, • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт нар 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 6 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Ерөнхий мэдээлэл:</p>	<p>Аймаг, сумдын орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 3,446.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16, шинээр хэрэгжих 14,015.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 161 зэрэг нийт 17,461.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 177 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна.</p> <p>Тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар 15,343.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 173 төсөл, арга хэмжээ /2024 онд үргэлжлэн хэрэгжихээр төлөвлөсөн 2,118.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ/ -г төлөвлөснөөс 10,537.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 136 төсөл, арга хэмжээ бүрэн, 2,300.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 2,505.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.</p>

**Бүлэг
А**

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, төлөвлөсөн үү?

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, иргэдийн санал аваагүй, хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцээгүй төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймаг, сумын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн үү?

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтыг бүрэн хангаагүй, иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

А.1.1 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 3,446.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16, шинээр хэрэгжих 14,015.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 161 зэрэг нийт 17,461.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 177 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./
Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5,678.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 1,768.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжихээр,
- 12 сумын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 11,772.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 133 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталснаас 1,666.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих, 10,105.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 нь шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ гэх мэт.

Сумдын 2023 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

Хүснэгт № 1

/ сая төгрөг /

№	Сумын нэр	Баталсан төсөл, арга хэмжээ	
		Тоо	Төсөвт өртөг
1	Алтанбулаг	2	105.0
2	Баруунбүрэн	10	215.1
3	Ерөө	12	2,713.3
4	Зүүнбүрэн	8	90.0
5	Мандал	8	767.3
6	Орхон	4	99.6
7	Орхонтуул	6	166.6
8	Сайхан	13	894.4
9	Сүхбаатар	28	2,004.3

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

10	Түшиг	5	181.0
11	Хүдэр	11	2,264.5
12	Шаамар	14	604.8
	Нийт дүн	121	10,105.9

Эх сурвалж: 2023 оны сумдын ИТХ-ын тогтоол

А.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь аймаг, сумдыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн, тэдгээрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төлөвлөгдсөн байхаар зохицуулагдсан байдаг.

А.1.3 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан төсөл арга хэмжээг дээрх бодлогын баримт бичгүүдтэй тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-тэй уялдаагүй 19, “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдаагүй 16 /давхардсан тоогоор/, “Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй уялдаагүй 20 төсөл, арга хэмжээг /давхардсан тоогоор/ аймгийн ИТХ-аар баталсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 1-д харуулав/
- Зүүнбүрэн, Орхон, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Хүдэр, Шаамар зэрэг 7 сум нь “Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилт, зорилготой уялдаагүй нийт 22 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав/

А.1.4 Дээрхээс бусад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймаг, сумдын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

А.1.5 Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлээр эрэмбэлж, үнэлсний үндсэн дээр төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлахаар зохицуулсан байдаг.

А.1.6 Аймгийн хувьд 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 172 төсөл, арга хэмжээний саналыг төсвийн байгууллага, сумын Засаг дарга нараас хүлээн авсан боловч хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлээр эрэмбэлж, үнэлэх ажлыг хийгээгүй байгаа нь дээрх журмын 2.1.2¹ дэх заалттай нийцэхгүй байна.

¹ Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэ журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 2.1.2.1.төслийн саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж эрэмбэлэх, үнэлэх.

А.2 Захиалагч нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, зураг төсөв, техникийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан уу?

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна

А.2.1 Захиалагч аймаг, сумдын Засаг дарга нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, зураг төсөв, техникийн баримт бичгийг Төсвийн тухай хууль, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн боловсруулахаар зохицуулагдсан байдаг.

А.2.2 Аймаг, сумд нь ОНХО-аар 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй, техникийн нөхцөл аваагүй, зураг төсөвгүй болон төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт өртөгт нь багтаан зураг, төсвийг хийлгэсэн зэрэг нийт 3,617.1 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./ Үүнд:

- *Аймаг 167.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, Ерөө, Хүдэр, Шаамар сумд нь 125.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 зэрэг нийт 9 төсөл, арга хэмжээний/ төсөвт өртгийн давхцал аймаг 151.0 сая төгрөг, сумд 2,401.1 сая төгрөгийг хасаж тооцсон./ зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй байгаа нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.5² дахь заалтыг зөрчсөн,*
- *Эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл /цахилгаан, ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл/ -ийг авалгүйгээр аймаг 4, Ерөө, Сүхбаатар, Шаамар сумд 200.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 зэрэг нийт 8 төсөл, арга хэмжээ / төсөвт өртгийн давхцал аймаг 318.1 сая төгрөг, сумд 508.1 сая төгрөгийг хасаж тооцсон./ -г төлөвлөж, баталсан байгаа нь Барилгын тухай хуулийн 37.1.3³ дахь заалтыг зөрчсөн,*
- *Аймаг 151.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Баруунбүрэн, Ерөө, Орхон, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Түшиг, Шаамар сумд 2,920.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 зэрэг нийт 29 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгүүлсэн бол Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Түшиг, Шаамар сумд нь нийт 183.0 сая төгрөг /төсөвт өртгийн давхцал нийт 125.0 сая төгрөгийг хасаж тооцсон./ -ийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг огт зураг, төсөвгүйгээр гүйцэтгэсэн байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29.4⁴, Барилгын тухай хуулийн 24.1.1⁵ дэх заалтыг тус тус зөрчсөн,*

² Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

³ Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.3.барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх.

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵ Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 24.1.1.батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Магадлалын дүгнэлтээр баталгаажуулбал зохих аймаг 3, Ерөө сум / төсөвт өртгийн давхцал аймаг 244.0 сая төгрөг, сумд 100.0 сая төгрөгийг хасаж тооцсон./ -ийн төсөвт өртөгтэй 7 зэрэг нийт 10 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг магадлал хийлгэж, баталгаажуулаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 25.2⁶, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.3⁷ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.


A.2.3 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дээрх төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан нь ажлын явц, хэрэгжилт удаашрах, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх улмаар төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд ашиглалтад оруулах боломжгүй байдалд хүрэх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

A.2.4 Аймаг, сумдын ОНХО-аар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан нийт 161 төсөл, арга хэмжээг шинж чанарын хувьд авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- *Машин, тоног төхөөрөмж худалдан авах 59 төсөл арга хэмжээ /нийт төсөл арга хэмжээний 36.6 хувь /-нд 2,346.1 сая төгрөг,*
- *Их засварын 51 төсөл, арга хэмжээ /нийт төсөл арга хэмжээний 31.7 хувь /-нд 4,504.2 сая төгрөг,*
- *Барилга байгууламжийн 37 төсөл, арга хэмжээ /нийт төсөл арга хэмжээний 23.0 хувь /-нд 6,746.8 сая төгрөг,*
- *Барилгын материал худалдан авах 7 төсөл, арга хэмжээ /нийт төсөл, арга хэмжээний 4.3 хувь/-нд 213.0 сая төгрөг,*
- *Зураг, төсөв боловсруулах 6 төсөл, арга хэмжээ /нийт төсөл, арга хэмжээний 3.7 хувь/-нд 185.5 сая төгрөг,*
- *Хогийн цэгийг түрж далан бий болгох буюу хот тохижилтын зардал болох 1 төсөл, арга хэмжээ /нийт төсөл, арга хэмжээний 0.7 хувь/-нд 20.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.*

Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №1 Батлагдсан төсөл, арга хэмжээ / төсөл, арга хэмжээний тоонд эзлэх хувиар/



Дүрслэл №2 Батлагдсан төсөл, арга хэмжээ /төсөвт өртгөөр, сая төгрөгөөр/



⁶ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁷ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд заавал магадлал хийнэ.

A.2.5 Аймаг, сумдын ОНХО-аар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 161 төсөл, арга хэмжээний 41.6 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанартай бус хэт жижиглэсэн буюу байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой нийт 1,003.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 төсөл, арга хэмжээ /аймаг 70.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, сумд 933.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59/ эзэлж байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав / Тухайлбал:

- Аймгийн ОНХО-аар 25.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн өмчийн газрын хурлын өрөөний завсар, тоног төхөөрөмж”, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “ Биологийн кабинет байгуулах /Цагааннуур сум/”, 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэрэлтүүлэг /Мандал сум, 4-р баг/”, 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж /Сүхбаатар сум, 5-р сургууль/”,
- Алтанбулаг сум 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагдаагийн эргүүлийн машин худалдан авах”, Баруунбүрэн сум 7.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн мооргийн өрөөний засвар”, Ерөө сум 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны Захирагчийн албаны дээвэр засвар”, Зүүнбүрэн сум тус бүр нь 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Компьютер техник хэрэгсэл”, “Хүүхэд хамгаалах өрөө байгуулах”, Сайхан сум 5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Спорт заалны засвар”, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хогийн цэгийг түрж далан бий болгох ажил”, Орхонтуул сум нийт 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Рашаант Эрүүл мэндийн төвийн халаалтын тогоо шинэчлэх”, 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Рашаант тосгоны Захирагчийн албаны халаалтын тогоо шинэчлэх”, Мандал сум 12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагаанчулуутын давааны зам засвар”, Түшиг сум 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “ЗДТГ-ын архивын өрөөний засвар”, Шаамар сум 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Халуун үнс, нурам түр хадгалах торх”, 3.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бохир шингээх цооног хийх” гэх мэт.

A.2.6 Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар улсын төсөвт байгууллагуудад автомашин, тоног төхөөрөмж, албан хаагчдын байр, барилгын материал худалдан авах, барилга байгууламжийг засварлах зэрэг 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 400.6 сая төгрөг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6.6.6⁸ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Улсын төсвийн байгууллагуудын урсгал зардлыг санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ

Хүснэгт №2

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Аймаг	Албан хаагчдын 10 айлын орон сууцны материал /Сүхбаатар сум, Хилийн цэргийн 0243 анги/	100.0
		Шүүхийн өргөтгөлийн барилгын засвар	38.1
2	Алтанбулаг сум	Цагдаагийн эргүүлийн машин худалдан авах	25.0
3	Ерөө сум	Цагдаагийн албан хаагчдын байр худалдан авах	40.0
		Цагдаагийн кабоны засвар	16.0
4	Сүхбаатар сум	МСҮТ-ийн спорт заалны засвар	24.0
5	Түшиг сум	Сумын цагдаагийн албанд автомашин	20.0

⁸ Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

		Автомашины тусгай тоноглол	8.0
6	Хүдэр сум	Цагдаагийн хэсэгт автомашин авах	70.0
		Цагдаагийн байрны гадна талбайн тохижилт, засвар камержуулалт	40.0
		Эрэн хайх салбарын автомашины гарааж барихад шаардагдах засвар үйлчилгээ	19.5
Нийт дүн			400.6

А.2.7 Аймаг, сумдын ОНХО-ын төлөвлөгөөнд тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих бус нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын засвар, айл өрхүүдэд цэвэр усны тоолуур суурилуулах зэрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, баталсан нь Төсвийн тухай хуулийн 4.1.24⁹ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- *Аймгийн ОНХО-аар 180.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн байруудын дээврийн засвар /Сүхбаатар, Цэнхэр 15-17 байр/”, 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн байрнуудын засвар /Сүхбаатар сум 7-р баг/”, 87.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “12 айлын байрны дээвэр /Сант сум/”, 77.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэвэр усны шугам солих, тоолууржуулах /Сүхбаатар сумын 7-р баг”,*
- *Сайхан сум нь 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Номгон тосгоны 12 айлын орон сууцны дээврийн засвар” гэх мэт.*

А.2.8 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргын төсөвт өртөгт багтаах зорилгоор дараах сумд нь ижил төрлийн ажлын төсөвт өртгийг хувааж төлөвлөсөн байна. Үүнд:

- *Баруунбүрэн сум нь 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт заалны шал шахах, засвар хийх болон 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын төвийн хувцас хэрэглэгдэхүүн төсөл, арга хэмжээг тус бүр 2 хуваасан,*
- *Зүүнбүрэн сум нь 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөдөлмөр зуслан байгуулах” ажлыг тус бүр 10.0 сая төгрөгийн өртгөөр 3 хуваасан,*
- *Сүхбаатар сум нь 30.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Номт хан, Эмнэх өрхийн ЭМТ-д оношилгооны тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээг 2 хуваасан,*
- *Түшиг сум нь 28.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумын Цагдаагийн албанд автомашин, автомашины тусгай тоноглол авах төсөл, арга хэмжээг 2 хуваасан,*
- *Шаамар сум нь 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хуванцар хог хаягдал цуглуулах сав, хуванцар сав пресслэх төхөөрөмж төсөл, арга хэмжээг 2 хуваасан гэх мэт.*

А.2.9 Мөн аймаг, сумдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээний зураг, төсөв боловсруулах ажлын санхүүжилтийг тусган баталсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.4.5¹⁰-дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

⁹ Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ.

¹⁰ Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Аймаг “Шинээр баригдаж буй төрийн байгууллагуудын инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн зураг төсвийн үнэ /Сүхбаатар сум, Баянхаан 4-р баг/, төсөл, арга хэмжээнд 100.0 сая төгрөг, “Дулаанхаан тосгоны захирагчийн албаны грашийн зураг төсвийн үнэ” төсөл, арга хэмжээнд 7.0 сая төгрөг,
- Хүдэр сум “Сумын ой зохион байгуулалтын төлөвлөгөөг шинээр хийлгэх” төсөл, арга хэмжээнд 45.5 сая төгрөг, “Сумын төвийн дулааны шугам засварлах ажлын зураг, төсөв” болон “Зураг, төсвийн үнэ” төсөл, арга хэмжээнд тус бүр 15.0 сая төгрөг, “Хурдан морь уралдах замын кадастрын зураг” төсөл, арга хэмжээнд 3.0 сая төгрөг гэх мэт.

А.2.10 Дээр дурдсанчлан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой, хэт жижиглэсэн, улсын төсөвт байгууллагуудын урсгал зардал болон зориулалт бус төсөл арга хэмжээг тусган баталсан нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг буруулж, зорилго зорилтыг алдагдуулж байна.

А.3 Аймаг, сумын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Төсвийн тодотголоор батлагдсан, хэрэгжүүлэх хугацаа оройтсон 870.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна

А.3.1 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 3,446.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16, шинээр хэрэгжих 14,015.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 161 зэрэг нийт 17,461.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 177 төсөл, арга хэмжээг тусган, баталсан байна.

А.3.2 Аймаг, сумдын өмнөх оноос шилжин хэрэгжих 720.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 /өмнөх онд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй./, шинээр хэрэгжих 14,015.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 161 зэрэг нийт 14,735.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 164 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс 13,440.0 сая төгрөгийн өртөгтэй 155 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулсан байна. Үүнд:

- 9,300.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар,
- 2,955.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар,
- 1,083.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэсэн. /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав./

А.3.3 Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/31 дүгээр захирамжаар буюу бүрэн хэрэгжих боломжтой хугацаанд нь нийт 752.0 сая төгрөгийн

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг дараах сумдын Засаг дарга нарт шилжүүлсэн байна. Үүнд:

- 119.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн барилгын засвар / Мандал, 2-р цэцэрлэг/”, 62.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн дээвэр, гадна фасад засварлах /Мандал, 4-р сургууль/” гэсэн 2 төсөл, арга хэмжээг Мандал сумын Засаг даргад,
- Нийт 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зураг, төсвийн зардал /Алтанбулаг сумын Ардын засгийн газрын түүхэн дурсгалт барилгыг сэргээх засварлах, Зүүнбүрэн сумын ЕБС-ийн барилга, Шаамар сумын гэр хорооллын гадна дулаан, цэвэр усны шугамын ажил, хүнсний ногооны зоорины барилга/” төсөл, арга хэмжээг Алтанбулаг, Зүүнбүрэн, Шаамар сумын Засаг дарга нарт.

А.3.4 Тайлант онд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.1.2¹¹ дахь заалт болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу дараах 2 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Онцгой комиссын 2023 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 11 дүгээр хуралдааны шийдвэрийн дагуу “Хараа голын гүүрний засвар /Мандал сум/” төсөл, арга хэмжээ /Засгийн газрын нөөц сангаас 1,500.0 сая төгрөг нийт 1,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ -г түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр Эрдэнэт суварга ХХК-тай шууд гэрээ байгуулж, 300.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор,
- Ерөө сумын Засаг дарга нь сумын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан 125.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ухаалаг худаг” төсөл, арга хэмжээг гүний усыг цэвэршүүлэн түгээх оюуны өмчийн патент эзэмшигч Баялаг говь ХХК-тай шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн.

А.3.5 Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа хийлгэж, хугацаа оройтсоноос тайлант онд гүйцэтгэх боломжгүй болж, нийт 870.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. Үүнд:

- Аймаг 430.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зураг, төсвийн зардал буюу 1 төсөл, арга хэмжээ,
- Ерөө сум 225.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,
- Орхонтуул сум 48.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Сайхан сум 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Мандал сум 36.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Түшиг сум 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,
- Хүдэр сум 45.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ гэх мэт

А.3.6 Захиалагч аймаг, сумдын Засаг дарга нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацаанд “Үнэлгээний хороо”-г 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсан боловч оролцогч санал ирүүлээгүй, ирүүлсэн санал нь шаардлага хангаагүй зэргээс шалтгаалж 13 төсөл, арга хэмжээний нээлттэй тендер шалгаруулалтыг 2-4 удаа

¹¹ Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно: 34.1.2.оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн зарлаж, тендер тус бүрд 60-90 хоног зарцуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

А.3.7 Сүхбаатар сум нь 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв хогийн цэгийн хашаа худалдан авалт” төсөл, арга хэмжээний нэршлийг “Хашаажуулах болон харуулын байр барих материал худалдан авах” гэж өөрчлөн, техникийн тодорхойлолтыг барилгын материал худалдан авахаар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

А.3.8 Гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэснээс бусад нийт 12,356.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг цахим системд мэдээлсэн бөгөөд тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав/

А.3.9 Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1¹²-д заасны дагуу тайлагнаж, хагас жилийн болон жилийн эцсийн тайланг Сангийн яаманд цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

Бүлэг Б

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгүүлж, хүлээн авсан уу?

2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 21.4 хувь нь дутуу болон огт хэрэгжээгүй байна

Б.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн үү?

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 136 төсөл, арга хэмжээ буюу 78.6 хувь нь бүрэн хэрэгжсэн байна

Б.1.1 Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 2023 онд хэрэгжүүлж дуусгах 15,343.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 173 төсөл, арга хэмжээ /2024 онд үргэлжлэн хэрэгжихээр төлөвлөсөн 2,118.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ батлагдсан./ -г төлөвлөснөөс гүйцэтгэл, хэрэгжилт нь дараах байдалтай байна. Үүнд:

- 10,537.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 136 төсөл, арга хэмжээ бүрэн,
- 2,300.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн,

¹² Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах хугацаанд ирүүлнэ. 3.1.1.Хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор, 3.1.2.Бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- 2,505.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Б.1.2 Өмнөх оноос он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн аймгийн 1,812.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, сумдын 1,477.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 зэрэг нийт 3,289.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээнээс 409.9 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бол дутуу хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээнд 114.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, огт хэрэгжээгүй 2 төсөл арга хэмжээнд санхүүжилт олгоогүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Өмнөх оноос шилжиж ирсэн дутуу болон огт хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	2023 онд санхүүжүүлсэн дүн	Тайлбар
1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх /Аймгийн хөрөнгө оруулалт/	860.0	60.0		2023 онд огт хэрэгжээгүйгээс санхүүжилт олгоогүй
2	Аймаг болон бусад 13 сумын зураг төсөв /Аймгийн хөрөнгө оруулалт/	500.0	500.0	60.0	Ажил бүрэн дуусаагүй учир дутуу санхүүжилт олгосон
3	Орон нутаг судлах музей, Хэрх тосгоны спорт заал, Зүүнхараа политехник коллежийн спорт заалны барилгын зураг төсөл боловсруулах /Мандал сум/	10.9	10.9		2023 онд огт хэрэгжээгүйгээс санхүүжилт олгоогүй
4	Тарни 8-р багт 6/04 кВ-ын 160 кВт дэд станц барих /Мандал сум/	54.3	10.9	3.0	Төмөр замын байгууллагаас зөвшөөрөл аваагүйгээс комисс ажиллаагүйгээс дутуу санхүүжилт олгосон
5	Түнхэл тосгонд 1,3 км явган хүний зам барих /5-р баг/ /Мандал сум/	204.1	53.8		Дутуу хэрэгжсэн тул санхүүжилт олгоогүй
6	Түнхэл тосгонд тоглоомын талбай байгуулах /Мандал сум/	250.0	112.0	51.6	Гүйцэтгэгч ажлаа бүрэн дуусгаагүй учир дутуу санхүүжилт олгосон
7	12-айлын зам талын 2 байрны фасад засвар /Мандал сум/	280.8	52.9		Зохиогч ашиглалтад авахаас татгалзсан тул санхүүжилт олгоогүй
	Дүн	2,160.1	800.5	114.6	

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

Б.1.3 Тайлант онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар 12,053.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 156 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас хэрэгжилт, гүйцэтгэл нь дараах байдалтай байна. Үүнд:

- 9,408.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 126 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэн,
- 1,010.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээ /аймаг болон Зүүнбүрэн, Сайхан, Сүхбаатар, Түшиг сум тус бүр 1, Хүдэр, Шаамар сум тус бүр 2/ дутуу хэрэгжсэн,
- 1,634.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээ /аймгийн 238.1 сая төгрөгийн 3, сумдын 1,396.2 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ/ огт хэрэгжээгүй байна.

Б.1.4 Аудитын дүнгээс харахад дийлэнх төсөл, арга хэмжээнүүд нь захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалан дутуу болон огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав/ Үүнд:

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- *Аймаг, сумдын төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж батлан, худалдан авах ажиллагааг оройтуулах, ажил гүйцэтгэх боломжгүй хугацаанд гэрээ байгуулах,*
- *Зураг төсвийг урьдчилан хийлгүйгээр төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс санхүүжилт дутагдах, зарласан худалдан авах ажиллагаанд санал ирэхгүй байх,*
- *Хэрэгжүүлэх ажлын тоо хэмжээ тодорхой бус, ажлын даалгаврыг бүрэн хийгээгүйгээс гүйцэтгэгч гэрээнээс татгалзах,*
- *Төлөвлөсөн төсвийн орлого бүрдээгүйгээс санхүүжилт хүрэлцэхгүй байх,*
- *Өөр өөр төсөл, арга хэмжээний байршил давхардсан, холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөлийг бүрэн аваагүй байх гэх мэт.*

Б.1.5 Харин гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүний нөөцийг бүрдүүлээгүй, гүйцэтгэх ажлыг зөв хуваарилаагүй, зураг, төсвийг мөрдөөгүй зэрэг нь төлөвлөсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэсэн байна.

Б.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд хууль тогтоомж, дүрэм журмын дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн үү?

3 сум нь 269.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна

Б.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын захиалагч аймаг, сумдын Засаг дарга нар нь "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.2¹³-т заасны дагуу "Барилга захиалагчийн хяналт, барилгын зураг төсөв хийх" чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулсны үндсэн дээр явцын болон техникийн хяналтыг гүйцэтгүүлсэн байна.

Б.2.2 "Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ нь "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 3.9¹⁴, 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2¹⁵-т заасны дагуу үе шат бүрд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулан, хяналтын тайлангаар баталгаажуулсан байна.

Б.2.3 Тус ОНӨААТҮГ нь 2023 онд 9,911.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний явцын болон техникийн хяналтыг хэрэгжүүлж, хяналтын зардалд нийт 110.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Б.2.4 Харин Хүдэр сум нь 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Спорт заалны барилга" төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг хяналт хэрэгжүүлэх чиг үүрэггүй, хүнсний дэлгүүр, бөөний худалдаа, газар тариалан, мал аж ахуй, мод, модон бүтээгдэхүүн худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг "Хүдэр өсөх ирээдүй ХХК"-

¹³ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹⁴ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

¹⁵ Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

иар гүйцэтгүүлэн хяналтын зардалд 5.1 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 37.2¹⁶ дахь заалт болон “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Б.2.5 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн автомашин, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах нийт 4,556.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 95 төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймаг, сумдын ЗДТГ хэрэгжүүлж, баталгаажуулсан байна.

Б.2.6 Харин Орхон, Сайхан, Хүдэр сумд нь ОНХО-аар хэрэгжүүлсэн нийт 269.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Орхон сум 38.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ухаалаг худгийн систем”, 31.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дэнж хорооллын гүний худаг”,
- Сайхан сум 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Номгон тосгоны 12 айлын орон сууцны дээврийн засвар”, тус бүр нь 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дөмбөн хорооллын хүүхдийн тоглоомын талбайг шинээр хийх”, “Нийтийн эзэмшлийн төв талбайн засвар”,
- Хүдэр сум 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагдаагийн байрны гадна талбайн тохижилт, засвар камержуулалт” төсөл, арга хэмжээ.

Б.2.7 Барилгын тухай хуулийн 37.1.5¹⁸, “Барилга захиалагчийн дүрэм”-3.1.4¹⁹-т заасны дагуу зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлсэн байна.

Б.2.8 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчид нь Барилгын тухай хуулийн 37.1.5²⁰, “Барилга захиалагчийн дүрэм”-3.1.4²¹, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2.3²², “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.3²³-т заасны дагуу төсөл, арга хэмжээний үе шат бүрд зураг, төсөв зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулан, зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтээр баталгаажуулсан байна.

¹⁶ Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹⁷ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹⁸ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

¹⁹ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

²⁰ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

²¹ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

²² Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан гүйцэтгэнэ: 3.2.3 барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

²³ Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрд зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Б.2.9 Мандал сумын 280.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “12-айлын зам талын 2 байрны фасад засвар” төсөл, арга хэмжээний чулуун замаскны өнгийг зөрүүлсэн гэж үзэн зохиогч ашиглалтад хүлээн авахаас татгалзсан байна.

Б.3 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож, бүртгэл тайланд бүрэн тусгасан уу?

Тайлант онд бүрэн хэрэгжсэн 33 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд нь бүртгэл тайланд тусгаагүй байна

Б.3.1 2023 онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжсэн 136 төсөл, арга хэмжээнд 8,932.8 сая төгрөг, дутуу хэрэгжсэн 18 төсөл, арга хэмжээнд 1,618.6 сая төгрөг /гэрээний дүн 3,003.7 сая төгрөг/ зэрэг нийт 10,551.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, дутуу хэрэгжсэн болон огт хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 3,090.2 сая төгрөгийг /дутуу хэрэгжсэн ТАХ-ний үлдэгдэл санхүүжилт 1,385.1 сая төгрөг, огт хэрэгжээгүй ТАХ-ний санхүүжилт 1,705.1 сая төгрөг/ орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Б.3.2 Аудитын явцад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох анхан шатны баримт материалтай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 3 сум дараах төсөл, арга хэмжээнд нийт 16.2 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон нь гүйцэтгэгчтэй байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-г зөрчсөн байна. Үүнд:
 - Сүхбаатар сум 207.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “СБ сумын 3, 5, 6-р багт шороон зам сайжруулах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнийн дүнгээс 13.9 сая төгрөг / тус зөрчлийг Сүхбаатар сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд зөрчлөөр авч албан шаардлага хүргүүлсэн/,
 - Орхон сум 31.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дэнж хорооллын гүний худаг” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид захиалагч болон зохиогчдын хяналтын зардал болох 1.6 сая төгрөгийг олгосон,
 - Хүдэр сум 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагдаагийн байрны гадна талбайн тохижилт, засвар камержуулалт” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид захиалагчийн хяналтын зардал болох 0.7 сая төгрөгийг илүү шилжүүлсэн,
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “Нийтийн эзэмшлийн байруудын дээврийн засвар /Сүхбаатар, Цэнхэр 15-17 байр/” төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлт болох 17.0 сая төгрөгийг гүйцэтгэгч “Нар сар газар ХХК”-тай нэмэлт гэрээ байгуулж, олгосон байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Сайхан сум 260.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв талбайн тохижилтын ажил” төсөл, арга хэмжээний гэрээг оройтож байгуулснаас хүйтний улирал эхлэн ажлын гүйцэтгэл хийгдээгүй байхад материал худалдан авсан гэх шалтгаанаар “Бэст вүүдэн ХХК”-д 70.0 сая төгрөг олгосон байна. Энэ нь гүйцэтгэгчтэй байгуулсан СЭАСХСЗДТГ/202301022 дугаар гэрээний 3 дахь “Захиалагч нь гэрээ албан ёсоор байгуулагдаж 40 хувь гүйцэтгэсний дараа гэрээний нийт үнийн дүнгийн 40 хувийн санхүүжилт, ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Мандал сум нь 2022 онд ямар ч төсөл, хөтөлбөрийн төсөвт тусгагдаж батлагдаагүй “Наадмын талбайн харуулын байр барих” төсөл, арга хэмжээг “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаа” дансны 36.5 сая төгрөгөөр “Гэгээн өргөө хаус ХХК”-иар гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгүүлсэн байна. Харин 2023 онд тус төсөл, арга хэмжээний санхүүжилт 36.5 сая төгрөгийг сумын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаа” дансанд буцаан төвлөрүүлсэн байна.
- “Хүлээн авсан комиссын акт”-гүйгээр Зүүнбүрэн, Хүдэр, Түшиг, Шаамар сумд нь 11 төсөл, арга хэмжээнд 123.8 сая төгрөгийн эцсийн санхүүжилтийг олгосон нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.9.1.6²⁴, 4.10.1.2²⁵-т заасныг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 3-т харуулав/ Үүнд:
- Аймаг, сумд нь 6 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардлыг тухайн ажлын төсөв, фото зураггүйгээр нийт 9.8 сая төгрөгийн ажил гүйлгээг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.17²⁶-д заасныг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Магадалшгүй ажлын зардлыг бүрдэл дутуу анхан шатны баримтаар олгосон төсөл, арга хэмжээ

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Олгосон магадалшгүй ажлын зардал
/Аймгийн хөрөнгө оруулалт/				
1	Хүчдэлийн уналттай айл өрхүүдэд цахилгааны шугам татах /Сүхбаатар сум, 5-р баг/	50.0	48.1	0.8
2	12 айлын байрны дээвэр /Сант сум/	87.0	81.6	1.4
3	Засаг даргын Тамгын газрын дээврийн засвар /Алтанбулаг сум/	50.0	46.9	0.8
4	Цэцэрлэгийн засвар, гадна талбайн ажил /Сүхбаатар 4-р цэцэрлэг/	60.6	60.6	1.1
/Сумдын хөрөнгө оруулалт/				
5	Цагдаагийн байрны гадна талбайн тохижилт, засвар камержуулалт /Хүдэр сум/	40.0	40.0	0.7
6	Сүхбаатар сумын гудамж талбайг камержуулах /Сүхбаатар сум/	300.0	298.4	5.0
	Дүн	587.6	575.6	9.8

- ТБОНӨХБАУХА тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6²⁷-д заасны дагуу аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 77.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цэвэр усны шугам солих тоолууржуулах” төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан 3.9 сая төгрөгийн барьцааг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй

²⁴ захиалагч нь эцсийн санхүүжилт хүсэх барилга байгууламжийн төслийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

²⁵ захиалагч нь их засварын ажлыг комиссын актаар ашиглалтад хүлээн авна.

²⁶ Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно.

²⁷ Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

бол аймаг, сумдын зарим төсөл, арга хэмжээний гэрээнд барьцааны нөхцөлийг тусгаагүй байна.

➤ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²⁸, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.30²⁹ дахь заалтуудыг зөрчин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж дууссан 33 төсөл, арга хэмжээний нийт 1,700.8 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд тусгаагүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 3-т харуулав/ Үүнд:


- Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 788.8 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ,
- Зүүнбүрэн, Мандал, Сайхан, Сүхбаатар, Хүдэр, Шаамар сумд нь 912.0 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ.

Б.4 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаагүй байна

Б.4.1 2023 онд хэрэгжсэн нийт 10,537.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 136 төсөл, арга хэмжээг салбаруудаар ангилж, дүрслэлээр харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл №3
Салбаруудад
хуваарилсан төсөл,
арга хэмжээ
/төсөвт өртгөөр,
сая төгрөгөөр/



Б.4.2 Дээрх дүрслэлээс харахад 2023 онд хэрэгжиж, санхүүжилт олгосон төсөл, арга хэмжээнд салбаруудын эзлэх хувийн жин дараах байдалтай байна. Үүнд:

- Зам гүүр барих, сайжруулах, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, цахилгаан дулааны хангамжийг нэмэгдүүлэх гэх мэт дэд бүтцийн чиглэлд 4,954.7 сая төгрөг буюу 47.0 хувь,
- Иргэдийн эрүүл чийрэг амьдрах нөхцөлийг хангах эрүүл мэнд, спортын чиглэлд 2,299.8 сая төгрөг буюу 21.8 хувь,
- Иргэдийг соён гэгээрүүлэх нөхцөлийг хангах боловсрол, соёл урлагийн чиглэлд 1,191.2 сая төгрөг буюу 11.3 хувь,

²⁸ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

²⁹ Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

- Хүрээлэн буй байгаль орчин, хөдөө аж ахуйн үйл ажиллагааг дэмжих чиглэлд 433.2 сая төгрөг буюу 4.1 хувь гэх мэт.



Хүдэр суманд хэрэгжсэн 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Спорт заалны барилга”



Ерөө суманд хэрэгжсэн 1,413.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгонд асфальт бетон хучилттай 3.97 км автозам”



Сайхан суманд хэрэгжсэн 242.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэрэлтүүлэг”



Ерөө суманд хэрэгжсэн 125.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ухаалаг худаа”,

Б.4.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тодорхой хэмжээний төсөв төлөвлөж, хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Нэгдсэн эмнэлэг, зарим сумдын ЭМТ, биеийн тамир, спортын байгууллагуудын барилга, инженерийн шугам сүлжээг засварлаж, шинээр бий болгосон, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаснаар ард иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн болон биеийн тамирын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн,
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, соёлын ордон, соёлын төвүүдийн барилга, инженерийн шугам сүлжээг засварлаж, сайжруулах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаснаар хүүхдийн сурах орчин нөхцөл сайжирч, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн,
- Цахилгаан, дулаан дамжуулах инженерийн шугам, сүлжээ, цэвэрлэх байгууламж, зам харгуй, гэрэлтүүлгийг засварлах, шинэчлэх өргөтгөх зэрэг төсөл, арга хэмжээнүүд хэрэгжсэнээр иргэд, оршин суугчдын тав тухтай амьдрах нөхцөл боломж тодорхой хэмжээгээр дээшилсэн гэх мэт.

Б.4.4 Гэвч аудитын явцад сум, орон нутагт ажиллаж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд оршиж байлаа. Үүнд:

- *Аймгийн хөрөнгө оруулалтаар 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Агропарк байгуулах /Орхон сум/” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр 6 ширхэг хүлэмжийг ашиглагч Орхон сумд хүлээлгэн өгсөн боловч зориулалтын дагуу ашиглаагүй байна.*
- *Сүхбаатар сум 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хогийг бутлах, пресслэх тоног төхөөрөмж”-ийг худалдан авсан боловч цахилгааны эх үүсвэрийг шийдээгүйгээс ашиглаагүй байна.*
- *70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв хогийн цэгийн хашаа худалдан авалт” төсөл, арга хэмжээг “Хашаажуулах болон харуулын байр барих материалыг худалдан авах” гэж нэршлийг өөрчилснөөр барилгын материал худалдан авсан боловч өнөөдрийг хүртэл хашаажуулах ажил хийгдээгүй. /Цагаан эрэг тохижилт ОНӨААТҮГ-ын хашаанд хураалттай байна./*
- *50.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эмнэх өрхийн ЭМТ-ийн цэвэр усны шугам, хоолой татах” төсөл, арга хэмжээг 2023 оны 06 дугаар сард комиссын актаар хүлээлгэн өгсөн боловч 11 дүгээр сард хөлдөж, ашиглагч байгууллага өнөөдрийг хүртэл цэвэр усаар хангагдаагүй байна.*
- *Мандал сум 277.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Техник дундын парк” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн “Шинэ мандал агро ОНӨААТҮГ”-ыг шинээр байгуулсан боловч зориулалтын дагуу ашиглаагүй, үр дүн гараагүй байна.*
- *Зүүнбүрэн сум 30 сая төгрөгийн төсөвт өртөгөөр сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвд ашиглагдах, нарийн ногоо тарьж, ургуулж, арчлан байгууллагуудын хэрэгцээг хангах зорилгоор “Хөдөлмөр зуслан”-г байгуулсан боловч зориулалтын дагуу ашиглаагүй, үр дүн гараагүй байна.*

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **5,390.0** сая төгрөгийн зөрчил илэрч, 2.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 3,996.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,390.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв. /Зөрчлийн нэгтгэлийг Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав./

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд нь зорилго, зорилтоо хангаж зохих үр дүнд хүрсэн хэдий ч тодорхой хэсэг нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй, иргэд, олон нийтийн санал авч, эрэмбэлэгдээгүй, хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.
- Тайлант онд хэрэгжихээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний 95.5 хувийг эзлэх 12,569.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлагнасан бол төсвийн тодотголоор батлагдсан, хэрэгжүүлэх хугацаа оройтсон 870.6 сая төгрөгийн

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилтийн 40.3 хувьтай тэнцэх 4,255.0 сая төгрөгийн ажил гүйлгээг бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйцэтгэж, шинээр бий болсон 1,700.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй нь хөрөнгө санхүүжилт үрэгдэх эрсдэлийг үүсгэж байна.
- Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.6 хувь буюу 136 төсөл, арга хэмжээ бүрэн, 8.1 хувь буюу 14 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 13.3 хувьтай тэнцэх 23 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй бөгөөд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний шалтгааныг тогтоож, үр дүнг үнэлэх ажил хийгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж болон сумдын Засаг дарга нарт:

- Хөрөнгө оруулалтын зорилго, зорилт, холбогдох төсөвлөлтийн шаардлагыг хангасан, төлөвлөсөн хугацаанд хэрэгжихүйц төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулах арга хэмжээ авч, орон нутгийн хөгжил, иргэд олон нийтэд хүрэх үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх.
- Төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт, гүйцэтгэгч, захиалагчийн хариуцлагыг сайжруулах, үр дүнг тухай бүр үнэлэх замаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд ашиглалтад оруулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх.
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглах нөхцөл, боломжийг хангах, дэд бүтцүүдийг бий болгох замаар төлөвлөсөн үр өгөөжийг хүртэх.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал болон сумдын төсвийн ерөнхий нягтлан бодогч нарт:

- Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн нотлох баримтуудыг үндэслэн санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэн, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх.
- Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгүүдийг бүртгэл, тайланд бүрэн тусгах замаар хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

С.БААСАНСҮРЭН

АУДИТОР

Ж.ЦОГТ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: Факс: 7036-2223. Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn

2024.06.19 № 01/192

танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Аймгийн орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус Аудитын дүгнэлттэй санал нийлж байгаа тул илэрсэн зөрчлийг арилгах ажлуудыг дахин давтахгүйгээр ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ж.САЙНЦОГ

430900949

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Хавсралт 1

Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Алдаа, зөрчлийн утга	Аймаг	Сумд											Нийт				
		Алтанбулаг	Баруунбүрэн	Ерөө	Зүүнбүрэн	Мандал	Орхон	Орхонтуул	Сайхан	Сүхбаатар	Хүдэр	Түшиг		Шаамар			
Зураг, төсвийн даалгавар боловсруулаагүй	167.1			125.0													292.1
Зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн	88.1		77.0		35.0	12.0								40.0	19.0		271.1
Төсөв батлагдснаас хойш төсөвт өртөгт багтаан зураг төсвийг хийлгэсэн	151.0			315.6		219.6	31.1	114.6	693.9	1,010.6		59.0		95.0	363.5		3,053.9
Зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажуулаагүй	+																-
Техникийн нөхцөлийг иж бүрэн аваагүй	+			+								+			+		-
Улсын төсвийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн	+	25.0		56.0								+	19.5	+			100.5
Иргэний өмчлөлд шилжих хөрөнгийг санхүүжүүлсэн	+																-
Харьцуулалтын аргаас зайлсхийж төсөвт өртгийг 2 хувааж шууд гэрээ байгуулсан			40.0		+							+		28.0	25.0		93.0
Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг өөрчлөн барилгын материал худалдан авсан												+					-
Зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй	+											+					-
Хяналт хийх эрхгүй этгээдэд хяналтын зардал олгосон													5.1				5.1
Захиалагчийн хяналтыг огт хэрэгжүүлээгүй.								38.5		+			+				38.5
Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнийн дүнгээс илүү дүнгээр санхүүжилт олгосон								1.6				13.9	0.7				16.2
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 40 хувьд хүрээгүй байхад санхүүжилтийг олгосон										70.0							70.0
Тендерийн хэмнэлтээр нэмэлт гэрээ байгуулан санхүүжилт олгосон	17.0																17.0
Хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулсан						+											-
Баталгаат хугацааны барьцааг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй	3.9																3.9
"Хүлээн авсан комиссын акт" үйлдэлгүйгээр санхүүжилтийг олгосон.					10.0								+	18.0			28.0
Бүрдэл дугуу анхан шатны баримтаар магадалшгүй ажлын зардлыг олгосон	4.1										5.0	0.7					9.8
Хэрэгжиж дууссан хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд бүрэн тусгаагүй	788.8				40.0	36.5			115.5	322.0	84.5				3.6		1,390.9
Нийт дүн	1,220.0	25.0	117.0	496.6	85.0	268.1	71.2	114.6	879.4	1,351.5	169.5	181.0	411.1				5,390.0

Зарим төсөл, арга хэмжээний зөрчлийн дүнгээс давхардлыг хасаж тооцсон болно.
Давхардсан зөрчлийг "+" тэмдгээр тэмдэглэсэн.